

Хүүхэд, гэр бүлийн эрүүл мэндийн үйлчилгээ

NSW мужид амьдарч буй 0 – 5 насны хүүхэдтэй гэр бүлүүдэд үнэгүй үйлчилнэ. Эмчийн лавлагаа авах шаардлагагүй.

Дараах үйлчилгээг үзүүлнэ:

- Эрүүл мэнд, өсөлт хөгжлийн үзлэгүүд
- Эцэг эхчүүдэд тулгардаг асуудлуудын тухай мэдээлэл
- Шаардлагатай тохиолдолд нэмэлт үйлчилгээ авах, лавлагаа олгох




Тархи болон бие махбодын хөгжил

Та бол хүүхдийнхээ хамгийн шилдэг багш юм.

Хүүхдийн тархи болон бие махбодын хөгжилд таны хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цаг хугацаа хамгийн чухал байдаг.

Зөвлөмж, мэдээллийг доорх линкээр авна уу:
health.nsw.gov.au/childdevelopment



Эрүүл мэнд, өсөлт хөгжлийн үзлэг

Эдгээр үзлэгүүд нь маш чухал бөгөөд таны хүүхдийн өсөлт, хөгжил хэрхэн явагдаж байгааг хянахад тань туслана.

Мөн таны хүүхэд нэмэлт дэмжлэг шаардлагатай эсэхийг мэдэж авахад тулах ба ингэснээр хүүхэд тань цаг алдахгүй тусламж авах болно.


Үзлэгүүдийг таны өрхийн эмч эсвэл хүүхэд ба гэр бүлийн эрүүл мэнд хариуцсан сувилагч гүйцэтгэх болно.

Таны хүүхдийг хамгийн сайн мэдэх хүн бол та

Битгий хүлээ. Хэрвээ таны хүүхэд тухайн насандаа тохирсон хөгжлийн үе шатад нэгээс илүү ур чадвараар нийцэхгүй, өмнөх ур чадвараа алдсан эсвэл бусад санаа зовнисон зүйл байвал эрт арга хэмжээ аваарай.

Өрхийн эмч эсвэл хүүхэд ба гэр бүлийн эрүүл мэнд хариуцсан сувилагчдаа хандан, санаа зовнисон асуудлаа хэлж, хөгжлийн үнэлгээ хийлгэх хүсэлт тавиарай.

Үзлэг бүрийн өмнө **Blue Book (Цэнхэр дэвтэр) дэх 'Learn the Signs. Act Early.'** (Шинж Тэмдгүүдийг Мэдэж Ав. Эрт Арга Хэмжээ Ав.) гэсэн шалгах хуудсыг бөглөөрэй.



October 2023 © NSW Health. SHPN (HSP) 230739-13.

NSW Health



Хүүхдийн хөгжлийн үе шат чухал

Milestones matter

Mongolian



Хүүхдээ амьдралд хөл тавихад нь хамгийн сайн эхлэлийг тавиарай

Хүүхэдтэйгээ цагийг чанартай өнгөрөөх
- Хайрлах, ярилцах, дуулах, хамт уншиж, тоглох

Хөгжлийн үе шатыг нь хянах
- Хэрхэн тоглож, суралцаж, ярьж, үйл хөдлөл гаргаж буйг хянах

Тэднийг эрүүл мэнд болон өсөлт хөгжлийн үзлэгт бүрэн хамруулах

Шинж Тэмдгүүдийг Мэдэж Ав. Эрт Арга Хэмжээ Ав.


Хүүхдийн эрт үеийн хөгжил бол түүний туулж өнгөрүүлэх үе шат юм. Насны ангиллаар нь хүүхдийнхээ хөгжлийн үе шатанд тэмдэглэгээ хийж яваарай. Тугт дүрсүүд нь таны хүүхэд эрүүл мэнд болон өсөлт хөгжлийн үзлэгт орох цаг болсныг илэрхийлнэ.

✓ **Эндээс эхэл**



6 – 8 Долоо хоног

- Таныг өөртэй нь ярихад инээмсэглэх эсвэл бусад руу инээмсэглэнэ.
- Чанга дуу чимээнд хариу үйлдэл үзүүлнэ.
- Гэдсээр нь хэвтүүлэхэд толгойгоо дааж өргөнө.
- Таныг хөдлөхөд дагуулан харна.



6 Сар

- Таны дуу авиаг дуурайна
- Суухдаа гараараа түшиж тулна.
- Ойр дотны хүмүүсээ танина.
- Хүссэн тоглоомоо авахаар гараа сунгана.
- Хэлээ булталзуулан "бөөрөлзгөнө" үлээнэ.



- "Баяртай" хэмээн гараа даллана.
- Таныг юм нууж байгааг хараад хайна.

12 Сар

- "Үгүй" гэхэд ойлгоно (таныг хэлэхэд түр азнах эсвэл хийж байгаа зүйлээ зогсооно).



18 Сар

- Таны хийдэг өдөр тутмын үйлдлийг дуурайна.

- Халбагаар идэх болон таггүй аягаар уухыг оролдоно.

- "Ээж" эсвэл "аав" гэхээс гадна гурав болон түүнээс олон үг хэлэхийг оролдоно.
- Хэн нэгнээс хөтлөх эсвэл юмнаас түшихгүйгээр бие даан алхана.

- Эцэг эхээ "эж", "аав" эсвэл өөр онцгой нэрээр дуудна.
- Өөрөө босохоор юмнаас татна.



2 Нас

- Асуухад дор хаяж хоёр биеийн хэсгээ зааж үзүүлнэ.
- Номон дээрх зүйлсийг нэрлэхийг хүсэхэд хуруугаараа заана.

- Дор хаяж 2 үг ашиглан ярина.
- Бусдыг ууртай эсвэл гунигтай байхыг анзаарна.

- Орхиж явсны дараа 10 минутын дотор тайвширна (цэцэрлэгт нь хүргэж өгөх гэх мэт)

- Асуухад нэрээ хэлнэ.
- Сул өмд, цамц зэрэг хувцсыг өөрөө өмсөнө.

- Тойрог зурж үзүүлэхэд дагаж зурна.
- Бусад хүүхдийг тоглохыг анзааран, хамт тоглоно.

- "Би хөл бөмбөг тоглосон" гэх мэт өдөрт хийсэн зүйлсээсээ дор хаяж нэгийг ярина.
- Том бөмбөг шидэхэд ихэнхдээ барьж авна.

- "Туслагч" байх дуртай байна.
- Байгаа орчноосоо хамааран зан авир нь өөрчлөгдөнө (тухайлбал номын сан, тоглоомын талбай).

- Гурав болон түүнээс олон биеийн хэсэг бүхий хүн дүрс зурна.



3 нас

4 нас